

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬ (ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА)-ИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээг Эдийн засаг, хөгжлийн яамнаас боловсруулсан Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн төслийн зүйл, хэсэг, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг илрүүлэн, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад зөвлөмж өгөх зорилгоор гүйцэтгэлээ.

Хуулийн төсөл нь шинэчилсэн найруулга хэлбэрээр боловсруулагдсан байна.

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /цаашид “Хуулийн төсөл” гэх/-ийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”² /цаашид “Аргачлал” гэх/-д заасны дагуу дараах үе шатаар хийлээ.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан Аргачлалын 2.9-д³ заасныг үндэслэн 6 шалгуур үзүүлэлтээс дараах 5 шалгуур үзүүлэлтийг сонголоо.

Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Практикт хэрэгжих боломж;
3. Ойлгомжтой байдал;
4. Хүлээн зөвшөөрөгдөх байдал;
5. Харилцан уялдаа зэрэг болно.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл:

1.Зорилгод хүрэх байдал:

Энэхүү үнэлгээний үндсэн зорилго нь тухай хуулийн төслийн зохицуулалт анх дэвшүүлсэн зорилго буюу тулгамдсан бэрхшээлийг шийдвэрлэж чадах эсэхийг тогтоох билээ. Иймд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн үзэл

¹ Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, <http://legalinfo.mn/law/details/11119?lawid=11119>.

²Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт.

³Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 2.9 “... хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан нэг, эсхүл хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг сонгож болно”.

баримтлал буюу хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

2. Практикт хэрэгжих боломж:

Хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулгад тусгасан зохицуулалтууд нь Хөгжлийн банканд тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, цаашид хэвийн үйл ажиллагаа явуулах боломжийг бий болгох ингэхдээ хуулиар зохицуулах боломжтой харилцаа байх шаардлагатай гэж үзсэн тул тус шалгуур үзүүлэлтийг сонгосон.

3. Ойлгомжтой байдал:

Хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектийн хувьд ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дүнд шууд нөлөөлдөг. Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар хуулийн төсөл нь бүтэц, хэлбэрийн хувьд логик дараалалтай, хэл зүй, найруулгын хувьд тодорхой, ойлгоход хялбараар томъёологдсон байх шаардлага тавигддаг.

Энэхүү хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд⁴ заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах тогтоох зорилгоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

4. Хүлээн зөвшөөрөгдөх байдал;

Хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулгад дурдагдсан зохицуулалтуудыг бүхэлд нь судлан энэ хуульд хамрагдах ашиг сонирхол нь хөндөгдөж болохуйц этгээдүүдийн хүлээн зөвшөөрөх байдлыг тодорхойлох зорилгоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

5. Харилцан уялдаа:

Хуулийн төслийн эх бичвэр нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомж болон төсөлд тусгагдсан зохицуулалт нь өөр хоорондоо зөрчилгүй байх, хуулиар үүрэг хүлээсэн субъектүүдийн чиг үүрэг давхардал, зөрчилдөөнгүй байх шаардлагатай. Иймд хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан агуулгын шаардлагыг⁵ хангасан эсэхийг шалгах зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгож байна.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг дараах байдлаар тогтоолоо.

Хүснэгт-1

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
------------	-------------------------	-------------------------------	------------------------

⁴Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт.

⁵Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйл.

1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх.
2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хөгжлийн банкны хэрэгжүүлэх зорилго зорилт, чиг үүрэг, эрх хэмжээ, санхүүжилт олгох зарчим, шаардлага, шаардлагатай нэр томьёо, ойлголтууд, засаглалын хэлбэр, шийдвэр гаргах процесс тодорхой ойлгомжтой болсноор Хөгжлийн банкны үйл ажиллагаанд нөлөөлөх, эерэг өөрчлөлт авчрах эсэхийг шалгах
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 24, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.
4	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалд заасны дагуу хуулийн төслийн зохицуулалтыг хэрэглэх этгээдүүд хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлэх боломжтой эсэх тухай хуулийн төслийн зохицуулалтын нөлөөлөхүйц байдал, хэрэгжих боломжийг судалж, дүн шинжилгээ хийх
5	Харилцан уялдаа	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10 дахь заалт болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурыг хангасан эсэхийг шалгах.

1.Зорилгод хүрэх байдал

Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ, агуулгад дүн шинжилгээ хийж үзвэл Монгол Улсын Хөгжлийн банкны хэрэгжүүлэх зорилго, зорилт, чиг үүрэг, эрх хэмжээ, санхүүжилт олгох зарчим, шаардлага, нэр томьёо, засаглалын хэлбэр, шийдвэр гаргах процессыг тодорхой ойлгомжтой болгох, хяналтын тогтолцоог тодорхойлох, нээлттэй, ил тод зарчмыг нэвтрүүлэхтэй холбогдсон эрх зүйн үндсийг тогтоох, компанийн засаглал, удирдлагын түвшинд эрх үүрэг, хариуцлагыг сайжруулан, тэдгээрийн хооронд үүсэх харилцааг зохицуулах замаар Монгол Улсын эдийн засгийг хөгжлийг дэмжих зорилготой байна.

Хуулийн төсөл, түүний үзэл баримтлал, танилцуулгаас үзэхэд дээрх зорилгыг багцлан дараах үндсэн таван зорилтыг тодорхойлж болохоор байна. Үүнд:

1. Хөгжлийн банкны эрх зүйн байдал, зорилго, зорилт, чиг үүрэг, эрх хэмжээг тодорхой болгох;
2. Хөгжлийн банкны эрхлэх санхүүгийн үйл ажиллагааны талаар болон санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрт тавигдах шалгуур, хэрэгжих нөхцөлийг тодорхойлох;

3. Засаглалын тогтвортой байдал, шийдвэр гаргах эрх хэмжээг оновчтой хуваарилах, санхүүжилтийг ил тод болгох;
4. Хөгжлийн банкны үйл ажиллагаанд тавигдах хяналтын тогтолцоог тодорхойлох;
5. Эрсдэлтэй активыг бууруулах талаар банкны үйл ажиллагааг боловсронгуй болгох, банканд учрах хохирлын хэмжээг бууруулах;

Дээр дурдсан зорилтуудыг хангах чиглэлээр тодорхой зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан байдлыг шалгаж үзвэл:

Зорилт-1.Хөгжлийн банкны зорилго зорилт, чиг үүрэг, эрх хэмжээг тодорхой болгохтой холбоотой нэмэлт, өөрчлөлт;

Одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа Хөгжлийн банкны тухай хуулийн бүтэц, эрхлэх үйл ажиллагааны цар хүрээ нь ашгийн төлөө арилжааны банкны үйл ажиллагаатай ерөнхийдөө ойролцоо зохицуулалтай. Зөвхөн харилцах, хадгаламж татан төвлөрүүлэхгүй, нэг зээлдэгчид олгох зээлийн хэмжээ өөрийн хөрөнгийг 8 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээтэйг тогтоосон зэрэг цөөн асуудлын хувьд ялгаатай байна.

Олон улсын сайн туршлагаудаас үзэхэд Хөгжлийн банкны зорилт нь дотоодын санхүүгийн байгууллагын зах зээл дээр өрсөлдөх бус харин бодлогын банкны хувьд банк, санхүү, хөрөнгийн зах зээлийн оролцогчидтой хамтарч, тэдний хүрч ажиллаж чадахгүй боловч төрийн бодлогын хүрээнд хөгжүүлэх шаардлагатай зорилтот салбаруудад төрөл бүрийн санхүүжилтийн арга хэрэгслийг ашиглан санхүүгийн зах зээлийн дутуу орон зайг нөхөх байдаг байна.

Иймд Хөгжлийн банкиг дээр дурдсан зорилтод нийцсэн үйл ажиллагааг явуулах үүднээс эрх зүйн байдлыг тодорхойлохдоо “бодлогын банк” болохыг нь тодотгож өгөн, зорилго, зорилт, чиг үүрэг, эрх хэмжээ, хориглох үйл ажиллагааг нь тодорхой болгон зохицуулснаар Хөгжлийн банк нь цаашид үйл ажиллагаагаа арилжааны банкнуудаас ялгаатай байдлаар буюу хөгжлийн төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх чиглэлээр дэмжлэг болох ач холбогдолтой байх тул хуулийн төслийн эдгээр зохицуулалтууд нь тус хуулийн төслөөр зохицуулах шаардлагатай нэгдүгээр зорилтыг хангаж байна.

Зорилт-2.Хөгжлийн банкны эрхлэх санхүүгийн үйл ажиллагааны талаар болон санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрт тавигдах шалгуур, хэрэгжих нөхцөлийг тодорхойлох;

Хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн 10.1-д Хөгжлийн банкнаас хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт тавигдах шалгуур, шаардлагыг тендерт оролцогч аж ахуйн нэгжид Өрийн удирдлагын тухай хуулиар тавьдаг шалгууртай ижил стандартаар хэт хатуу, ерөнхий тавьсан нь банкны төлөөлөн удирдах зөвлөл бодлогын хувьд санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн бодлого, стратегийг салбарын болон бизнесийн онцлог, хэрэгжүүлэх төслийн бүтэц, санхүү, хөрөнгө оруулалтын тооцоолол, төсөл хэрэгжүүлэгчдийн хоорондын гэрээ, хэлцлийн нөхцөл зэрэгт нийцүүлж, гадаад, дотоод зах зээлийн өөрчлөлт, нөхцөл байдалтай нийцүүлж, өөрчилж, шинэчлэх боломжгүй болгосон байжээ.

Тухайлбал, “Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцсэн, эдийн засаг, санхүүгийн үр ашигтай” төсөл байх, мөн зүйлийн 10.2-т “энэ

хуулийн 10.1-д заасан шаардлага хангасан төсөл, хөтөлбөрийг дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулагчидтай хамтран санхүүжүүлэх; мөн зөвхөн хуулийн 10.1.2-10.1.5-д заасан шаардлага хангасан төсөл, хөтөлбөрт баталгаа, батлан даалт гаргах хуулийн шаардлага Хөгжлийн банк бизнесийнхээ хувьд бусдаас хэт хамаарсан, зорилтот зах зээлийнхээ нөхцөл байдалд тохируулан үйл ажиллагаагаа эрхлэх боломжийг хаасан зохицуулалт болсон байна.

Хуулийн төсөлд Хөгжлийн банкны эрхлэх санхүүгийн ажил, үйлчилгээний бодлогын баримт бичиг, журам, аргачлалыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандарт аргачлалаар баталж, хэрэгжүүлэх боломжийг хуулиар олгож, банк өөрийн стратегийн хүрээнд ажил, үйлчилгээнийхээ онцлогт нийцсэн хөрөнгө оруулалт, санхүүжилт, эрсдэлийн болон дотоод хяналтын бодлого, журмыг боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөл нь баталж, мөрдүүлж, хяналт тавьдаг болгохоор зохицуулжээ.

Мөн Монгол Улсын Хөгжлийн банк нь Монгол улсын тогтвортой хөгжлийг хангах, эдийн засгийн өсөлтийг бий болгох, экспортыг дэмжих төсөл хөтөлбөрийг санхүүжүүлж, экспорт, импорт, худалдааны санхүүжилтийн цогц үйлчилгээ үзүүлэх бодлогын банк байхаар 5 дугаар зүйлийг өөрчлөн найруулсантай холбогдуулан эрхлэн хэрэгжүүлэх санхүүгийн ажил үйлчилгээг хуулийн төслийн 14-25 дугаар зүйлүүдээр нарийвчлан тодорхойлжээ.

Ингэснээр Хөгжлийн банкны тухай хуулийн 14-р зүйлд заасан Хөгжлийн банкны эрхлэх санхүүгийн үйл ажиллагаа өргөжиж, бодит байдлаар хэрэгжих боломж бүрдсэн байх бөгөөд өнгөрсөн хугацаанд Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрүүд амжилтгүй болж дийлэнх зээлүүд чанаргүй актив шилжсэн нөхцөл байдлыг залруулах үүднээс үйлчилж буй хуулийн хийдэл буюу тодорхой бус байдал (хуулиар тогтоосон шаардлага нь хэт ерөнхий зарим тохиолдолд хангагдсан эсэхийг тодорхойлох боломжгүй)-ыг арилгахад чиглэсэн өөрчлөлтүүдийг хуулийн төсөлд тусгасан нь тус хуулийн төслөөр зохицуулах шаардлагатай хоёрдугаар зорилтыг хангаж байна.

Зорилт-3.Засаглалын тогтвортой байдал, шийдвэр гаргах эрх хэмжээг оновчтой хуваарилах, санхүүжилтийг ил тод болгоход чиглэсэн нэмэлт, өөрчлөлт;

Хуулийн төсөлд санхүүгийн ажил, үйлчилгээнд тавигдах шаардлагыг тогтоож, улмаар тухайн шаардлагуудыг хангаж байгаа эсэхэд Хөгжлийн банк мэргэжлийн үүднээс дүгнэлт хийж, санхүүжилт олгох эсэх эцсийн шийдвэрийг гүйцэтгэх удирдлага бие даан гаргадаг байх, хуулиар тодорхойлоогүй нарийвчилсан шаардлагыг төлөөлөн удирдах зөвлөлөөс нарийвчлан баталдаг байхаар зохицуулжээ.

Төлөөлөн удирдах зөвлөл нь банкны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, гүйцэтгэх удирдлага нь батлагдсан төлөвлөгөө, хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу ажиллаж буй эсэх, хувийн ашиг сонирхлоос ангид байгаа эсэхэд хяналт тавих буюу бодлогын чиглэл өгч, хяналтын чиг үүрэгтэй ажиллахаар тусгасан байна.

Гүйцэтгэх захирлыг төлөөлөн удирдах зөвлөлөөс хугацаатай томилж, зөвхөн хуульд заасан үндэслэлээр чөлөөлөх, гүйцэтгэх захирал нь өөрийн багаа бүрдүүлж, тэдэнтэй гэрээ байгуулах, цуцлах эрхтэй байхаар зохицуулжээ. Шалгуур хангасан

төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх шийдвэрийг Хөгжлийн банкны төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан тухайн жилийн бизнес төлөвлөгөөнд нийцүүлэн Хөгжлийн банкны тухай хуулийн болон төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан шаардлагад нийцүүлсэн байхаар зохицуулжээ.

Эдгээрээс үзэхэд өнгөрсөн хугацаанд банкны өдөр тутмын үндсэн үйл ажиллагаа болох зээл олгох эсэх шийдвэр гаргах болон бодлогын шийдвэр гаргах эрх хэмжээг ялгаж зааглалгүйгээр Төлөөлөн удирдах зөвлөлд бүхэлд нь хариуцуулж байсан нь Хөгжлийн банкны үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж ирсэн. Улмаар Төлөөлөн удирдах зөвлөлийн хамгийн чухал чиг үүрэг болох хяналт тавих чиг үүрэг орхигдсон, гаргасан шийдвэрийн хариуцлагыг хүлээх субъект тодорхой бус болсон зэрэг сөрөг үр дагаврыг арилгах зорилгоор шийдвэр гаргалтад оролцож буй албан тушаалтнуудын эрх хэмжээг тодорхой болгох чиглэлээр зохицуулалтыг нэмсэн байна.

Мөн Гүйцэтгэх захирал болон түүний багийн гишүүдийг төлөөлөн удирдах зөвлөл тодорхой үндэслэлгүйгээр томилж, чөлөөлөх эрх хэмжээтэй байснаас эрх мэдлийн хуваарилалт алдагдаж гүйцэтгэх удирдлагын тогтворгүй байдлыг бий болгосон алдааг залруулах чиглэлээр зохицуулалтуудыг нэмжээ.

Эдгээрээс гадна Хөгжлийн банкнаас санхүүжүүлж буй төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, түүний хэрэгжилтийн явц, судлагдаж буй төсөл, хөтөлбөрийн талаарх мэдээллийг нээлттэй, ил тод болгохоор зохицуулсан нь гуравдугаар зорилтод бүрэн нийцэж байна.

Зорилт-4.Хөгжлийн банкны үйл ажиллагаанд тавигдах хяналтын тогтолцоог тодорхойлох;

Хөгжлийн банк нь Засгийн газрын баталгаатайгаар гадаад улсаас хамгийн хямд эх үүсвэрийг татаж, Монгол Улсын эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилгоо бүрэн дүүрэн хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлуудын нэг бол шүүхээр хэрэг хянан шийдвэрлэгдэх процесс удаашралтай байдаг нь эрсдэлийг нэмэгдүүлж, зээлийн хүүг өндрөөр тооцохоос өөр аргагүй байдалд хүргэдэг юм.

Нөгөө талаас, Хөгжлийн банкны санхүүжилт авсан зээлдэгчийг хариуцлагатай байлгах, Хөгжлийн банк санхүүжилтийн зарцуулалтад хяналт тавих хангалттай хуулийн эрх хэмжээ байхгүй байсаар байна. Хөгжлийн банкны чанаргүй зээлдэгчдээс зээлийн санхүүжилтийг зориулалтын бусаар ашигласан, зээлийн зарцуулалт баримтаар нотлогдохгүй, төсөл хэрэгжээгүй тохиолдлууд түгээмэл байгаа нь зээлдэгч болон зээл олгогч нь анхнаасаа төсөл хэрэгжүүлэх санаа зорилгогүй байсан магадлал өндөр байгааг илтгэх ба энэ нь төслийн хэрэгжилтэд тавих хяналт сул, хуулиар хүлээлгэх хариуцлагын тогтолцоо дутмаг байгаагийн илрэл гэж үзнэ. Энэ нь авлига, ашиг сонирхлын зөрчлийг өөгшүүлж, судалгаа шинжилгээ, тооцоололд суурилсан мэргэжлийн шийдвэр гаргах бус хувийн ашиг сонирхолд суурилж шийдвэр гаргах шалтгаан болж байна.

Түүнчлэн, Хөгжлийн банкны үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтуудаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байсан, шалгалт хийсэн байгууллагууд нь зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч байгаагүй, төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх дотоод хяналтын нэгж энэ бүх хугацаанд ямар чиг үүргийг хэрэгжүүлж байсан нь тодорхойгүй зэрэг нөхцөл байдлуудад дүгнэлт хийж, Хөгжлийн банкны

үйл ажиллагаанд хяналт тавих Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, Монголбанкны бүрэн эрхийн тус тус ойлгомжтой болгох, Хөгжлийн банкны хянан шалгагчийн эрх хэмжээг тогтоох зорилгоор дөрөв, тавдугаар бүлгийг өөрчлөхөөр төсөлд тус тус тусгажээ.

Эдгээр зохицуулалт нь хэрэгжих боломжтой зохицуулалтууд байх тул дөрөвдүгээр зорилтод нийцэж байна.

Зорилт-5.Эрсдэлтэй активыг бууруулах талаар банкны үйл ажиллагааг боловсронгуй болгох, банканд учрах хохирлын хэмжээг бууруулах;

Гэсэн хэдий ч банкны актив хөрөнгө 2017 онд 5.8 их наяд төгрөг байсан бол өнөөдрийн байдлаар 2.8 дахин буурч, 2.46 их наяд төгрөг болсон бөгөөд банк шинээр зээл олгох, төсөл санхүүжүүлэх, эх үүсвэр татах үндсэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлээгүй удаан хугацаанд зогсонги байснаас үйл ажиллагааны хүрээ хумигдаж, цаашид хуулиар зөвшөөрсөн үндсэн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулахад хүндрэлтэй болоод байна. Иймд эрх зүйн шинэчлэл хийж, институтийн чадамжийг сайжруулах зайлшгүй шаардлага бий болжээ.

Хөгжлийн банк чанаргүй активын эрсдэлийг бууруулах зорилгоор эрсдэлтэй активт бүтцийн өөрчлөлт хийх, банкны мэргэжлийн байгууллагуудын ашигладаг арга хэрэгслийг ашиглах талаар 41 дүгээр зүйлд нэмж тусгаж, арга хэмжээ авах заалт оруулсан нь хэрэгжих боломжтой зохицуулалтууд байх тул дөрөвдүгээр зорилтод нийцэж байна гэж үзлээ.

Практикт хэрэгжих боломжтой эсэх:

Энэхүү шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхийг Хуулийн төслийн танилцуулга болон хуулийн төсөлд дурдагдсан дараах асуудлуудыг хуулиар зохицуулах боломжтой эсэх, түүнийг хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар судалж үзлээ.

Хуулийн төслөөр нэмэгдэж, өөрчлөгдөж буй зохицуулалтууд	Практикт хэрэгжих боломж	Үр нөлөө	Тайлбар
1. Хуулийн Нэгдүгээр бүлэгт хуульд хэрэглэгдэх санхүүгийн ажил үйлчилгээний талаарх ойлголтыг энэ хуульд хэрэглэх нэр томъёоны 4-р зүйлд нэмж тодорхойлсон;	тийм	ээрэг	Хуулийн төслийн нэр томъёоны тайлбар хэсэг нь тухайн хуульд хэрэглэгдэж буй мэргэжлийн болон салаа утгатай байж болохуйц үг өгүүлбэрийг нэг утгатай ойлгож хэрэглэхийг хууль хэрэгжүүлэгчид даалгасан шинжтэй байдаг.
2. Хөгжлийн банкны эрх зүйн байдал, зорилт, үйл ажиллагааны чиглэл, эрх хэмжээ, хориглох үйл ажиллагаа, банканд тавигдах шаардлага, үйл ажиллагаанд тавигдах хязгаарлалтыг хуулийн Нэгдүгээр бүлэгт тодорхой болгож тусгана.	тийм	ээрэг	Хөгжлийн банк нь цаашид бодлогын банк болохынхоо хувьд Монгол Улсын УИХ, Засгийн газрын бодлогод нийцсэн хөгжлийн төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх боломжтой болох шаардлагатай. Үүний тулд эрх хэмжээ, хориглох үйл ажиллагаа болон зорилго зорилтыг тодорхойлсон нь хууль хэрэгжүүлэгчдэд хуулийг хэрэглэхэд хялбар болгоно.
3.Хөгжлийн банкны санхүүгийн ажил үйлчилгээг банкны зорилго,	тийм	ээрэг	Өмнөх хуулиудын зохицуулалтаар “үйл ажиллагааны хүрээ” гэх

<p>зорилттой нийцүүлэн хуулийн Хоёрдугаар бүлэгт буюу 14-23 дугаар зүйлийг өөрчлөн найруулж, 24, 25 зүйлүүдэд тогтвортой, ногоон санхүүжилт олгох болон экспортыг дэмжих зорилгоор экспортын зээлийн баталгаа гаргах, экспортын даатгал хийхтэй холбоотой ажил үйлчилгээг нэмж тусган Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх санхүүжилтийн хүрээнд үзүүлэх санхүүгийн ажил үйлчилгээнд зорилтот салбарт экспортын санхүүжилт олгох, баталгаа, батлан даалт гаргах зэрэг шинэ, бүтээгдэхүүн үйлчилгээг тодорхойлно.</p>			<p>агуулгаар томъёологдсон байсан ойлголтыг “Санхүүгийн ажил, үйлчилгээ” гэх агуулгаар томъёолж улмаар тус ойлголтуудыг нэг бүрчлэн зүйл хуульд тусган тодорхойлох замаар, тавигдах шаардлага, шийдвэр гаргах субъектийг ойлгомжтой болгосон байна. Мөн санхүүжилтийн төрөл бүрийг нарийвчлан тодорхойлохдоо Хөгжлийн банкнуудын үндсэн үйл ажиллагаа болох Төслийн санхүүжилт, экспорт импортын санхүүжилтийн ойлголтуудыг илүү дэлгэрэнгүй тодорхойлжээ.</p>
<p>4.Хөгжлийн банкны үйл ажиллагаанд засаглалын тогтвортой байдал, шийдвэр гаргалтын эрх хэмжээг зөв хуваарилах, үүрэг, хариуцлагыг тодорхой зааж өгөх зорилгоор Хөгжлийн банкны төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, тэдгээрийг томилох чөлөөлөх асуудлыг 26 дугаар зүйл, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд тавигдах шалгуурыг 27 дугаар зүйл, төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг 30 дугаар зүйлүүдэд шинэчлэн найруулж, төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны талаар 29 дүгээр зүйлийг нэмсэн. Гүйцэтгэх удирдлагын хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор гүйцэтгэх удирдлагыг томилох, сонгон шалгаруулах асуудлыг 31 дүгээр зүйлд, гүйцэтгэх захиралд тавигдах шалгуурыг 32 дугаар зүйлээр, гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх, үүргийг 33 дугаар зүйлүүдэд тус шинэчлэн найруулсан.</p>	<p>тийм</p>	<p>анхаарах</p>	<p>Хуулийн танилцуулга, тандан судалгаанаас үзэхэд Хөгжлийн банканд үүсээд буй өнөөгийн нөхцөл байдлыг засаглалын тогтворгүй байдал, шийдвэр гаргалтын эрх хэмжээний хуваарилалт ойлгомжгүй, үүрэг, хариуцлагыг тодорхой зааж өгөөгүй зэрэг сул талуудыг арилгах зорилгоор энэхүү зохицуулалтыг оруулсан байна. Иймд тус зохицуулалтууд нь хэрэгжих боломжтой байхын тулд өмнөх эрх зүйн зохицуулалтуудын сул талыг хэрхэн нөхөж байгааг анхааран судалж үзвэл Хөгжлийн банкны засаглалыг компанийн засаглалын олон улсын зарчимд нийцүүлж, эрх хэмжээний хуваарилалтууд нь компанийн тухай хууль тогтоомжид нийцсэн байна. Гэвч Хөгжлийн банкны засаглалын асуудал нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн ур чадваргүй байдал, хэрэгжүүлэгч эрх бүхий албан тушаалтнуудын хүсэл зориг зэрэг субъектив хүчин зүйлээс үүдэлтэй байж болзошгүй байгааг анхаарах шаардлагатай байна.</p>
<p>5.Хөгжлийн банкны үйл ажиллагаанд Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх, Засгийн газрын бүрэн эрх, Монголбанкны хяналтыг ойлгомжтой болгох зорилгоор Дөрөвдүгээр бүлгийг Хөгжлийн банкнаас бусадтай харилцах зарчмыг ойлгомжтой болгож өөрчилнө.</p>	<p>тийм</p>	<p>анхаарах</p>	<p>Хөгжлийн банкны үйл ажиллагаанд Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, Монголбанк зэрэг улсын эдийн засгийн бодлогод нөлөөлөх шийдвэр гаргадаг оролцогч байгууллагууд нь Хөгжлийн банкны хувьцаа эзэмшигчийнхээ хувиар бус үндсэн чиг үүргийнхээ хүрээнд харилцах, тус асуудлаар эдлэх эрх хэмжээг тодорхойлсон нь хэрэгжих боломжтой зохицуулалт байна.</p> <p>Гэвч тус зохицуулалтууд батлагдсанаар зарим хууль тогтоомжид өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг анхаарч судлах шаардлагатай.</p>

<p>6.Хөгжлийн банк чанаргүй активын эрсдэлийг бууруулах зорилгоор эрсдэлтэй активт бүтцийн өөрчлөлт хийх, банкны мэргэжлийн байгууллагуудын ашигладаг арга хэрэгслийг ашиглах талаар 41 дүгээр зүйлд нэмж тусгана.</p>	<p>тийм</p>	<p>ээрэг</p>	<p>Хөгжлийн банк нь цаашид үндсэн чиг үүрэг, бусад орнуудын Хөгжлийн банкнуудын сайн туршлагад нийцсэн үйл ажиллагаа явуулахын тулд өнөөгийн нөхцөл байдал буюу чанаргүй актив их хэмжээгээр хуримтлагдсан нөхцөл байдлыг залруулах зайлшгүй шаардлагатай. Гэвч шийдвэр гаргах субъектийн ойлгомжгүй байдал, процессын тодорхойгүй байдал зэргээс шалтгаалан дээрх арга хэмжээнүүдийг авахад хүндрэл үүсэж болзошгүй. Иймд тус зохицуулалтыг хэрэгжүүлэх, процесс ажиллагааг тодорхой болгох нэмэлт журмуудыг боловсруулж батлах шаардлагатай.</p>
<p>7.Банкнаас санхүүжүүлсэн, санхүүжүүлэх төслийн үйл явц, хэрэгжилтийн байдал, санхүүжилтийн талаарх мэдээллийг нээлттэй, ил тод болгох заалтыг 30.4 дэх хэсэгт нэмж тусгана.</p>	<p>тийм</p>	<p>ээрэг</p>	<p>Энэхүү зохицуулалт нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, түүний үзэл баримтлалтай нийцэж байх тул хэрэгжүүлэх боломжтой гэж үзлээ.</p>
<p>8. хуулийн зүйл, заалт хоорондын давхардал, зөрчлийг арилгах, уялдаа холбоог сайжруулахтай холбоотой зарим өөрчлөлт, найруулгыг хийнэ.</p>	<p>тийм</p>	<p>анхаарах</p>	<p>Хуулийн төсөл дотор байх хэм хэмжээг эшлэх, бусад хууль тогтоомжийг ишлэх, дагалдан гарах шаардлагатай хууль тогтоомжийг бүрэн тодорхойлж чадсан эсэх зэрэг асуудлыг анхаарах шаардлагатай.</p>

Дээрхээс үзэхэд Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь 8 үндсэн агуулгаас бүрдэж байх бөгөөд тэдгээрийг энэхүү хуулиар зохицуулсаар үүсэх үр нөлөө нь эерэг байх бөгөөд зарим асуудлыг анхаарах шаардлагатай байх тул практикт хэрэгжих боломжтой гэж үзлээ.

3.Ойлгомжтой эсэх

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд “Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төсөл боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн 26, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг гүйцэтгэлээ.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дугаар зүйлд зааснаар хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлбэрээр бичигдсэн, хуулийн төслийн бүтцийн дугаарлалт хуульд заасан шаардлагыг хангасан байна.

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан хуулийн бүтэц, хэлбэрт нийцсэн байна.

4. Хүлээн зөвшөөрөгдөх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг тооцох хэсгээ тогтоосон байдал

Тус шалгуурын хүрээнд Хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулгад дурдагдсан зохицуулалтуудыг бүхэлд нь судлан дүгнэлт гаргасан.

Үүнтэй холбогдуулан энэ хуульд хамрагдах ашиг сонирхол нь хөндөгдөж болохуйц этгээдүүдийг доорх хүснэгтээр авч үзье.

№	Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг	Нөлөөлж буй хэлбэр
1	Иргэд	Хөгжлийн банкны тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд санхүүжилтийн шаардлага тодорхой болох, засаглалын хувьд хяналттай бөгөөд улс төрөөс хараат бусаар шийдвэр гаргах, санхүүжилтийг зориулалтын бусаар зарцуулах боломжгүй болох зэрэг зорилтууд хэрэгжсэнээр хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөр амжилттай хэрэгжиж, макро эдийн засагт эергээр нөлөөлөхөөр байна.
2	Төр	Хуулийн төслийн хүрээнд Хөгжлийн банканд үүссэн өнөөгийн нөхцөл байдлаас улбаалан болзошгүй өр төлбөрийн дарамт нэмэгдэж сөргөөр нөлөөлж байгааг арилган эергээр нөлөөлөхөөр байна.
3	Бизнес эрхлэгчид	Хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиар Хөгжлийн банкны эрх хэмжээ, санхүүжилтийн төрлүүд, тэдгээрт тавигдах шаардлага, засаглал, эрх мэдлийн хуваарилалтын тодорхойгүй байгаа нь бизнес эрхлэгчдийн өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлж байсныг залруулах боломжтой байна.
4	Гаднын санхүүжүүлэгчид	Хөгжлийн банкны тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Монгол Улсын Хөгжлийн банканд үүссэн өнөөгийн нөхцөл байдлаас улбаалан итгэл алдрах, санхүүжилт олгохоос татгалзах зэрэг нөхцөл байдал үүсэж улмаар олгосон санхүүжилтээсээ алдагдал хүлээх эрсдэлийг залруулах боломжтой байна.
5	Монгол Улсын Хөгжлийн банк	Хөгжлийн банкны тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Хөгжлийн банкны засаглалд улс төрийн нөлөө хэт их, тогтвортой бус байгаагаас шалтгаалж үр ашиггүй, эргэн төлөгдөх боломжгүй, шаардлага хангагдаагүй төслүүдэд санхүүжилт олгох улмаар санхүүжилт татах эх үүсвэрийн зардал өсөх, дефолт зарлах зэрэг сөрөг нөлөөг арилгах боломжтой байна.

5. Харилцан уялдаатай байдлыг хангасан эсэх:

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт дурдагдсан нийтлэг шаардлагуудаас харилцан уялдаатай холбогдох 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10 дахь заалтуудад заасан нийтлэг шаардлагууд болон Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.10-т заасан шалгах хэрэгслийн дагуу үнэллээ:

- *Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх:*

№	Шалгах асуулт	Шаардлагыг хангасан эсэх
1	29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байна.
2	29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Төслийн зүйл, хэсэг, заалт хоорондоо зөрчилдөөгүй байна.
3	29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Энэхүү хуулийн төслийн зүйл, заалт бусад хуулиудтай давхардаагүй бөгөөд шаардлагатай тохиолдолд бусад хуулиас эш татсан байна.
4	29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Тус хуулийн төслийг дагаж нэмэлт, өөрчлөлт оруулах 8 хуулийн төслийг боловсруулсан байх бөгөөд нэмэлт хуулийн төслүүд боловсруулах шаардлага үүсэж болзошгүй анхаарах, тухайлбал, банкны тухай хууль, зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль гэх мэт.

- Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.10-т заасан уялдаа холбоог шалгах хэрэгсэлд дурдагдсан шалгуурыг хангасан эсэх:

д/д	Асуулт	Хариулт	Дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн	Тийм	Хуулийн төслийн зохицуулалт нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтыг бүрэн хангаж байна.

	хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;		
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Тийм	Энэхүү шаардлагыг хангасан байна.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;	Тийм	Энэхүү шаардлагыг хангасан байна.
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Тийм	Зарчмын зөрүүтэй ямар нэгэн асуудал дүн шинжилгээний хүрээнд илрээгүй болно.
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Үгүй	Энэхүү шаардлагыг хангасан байна.
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Тийм	Хуулийн төслийг хэрэгжүүлэгч субъектүүдийн эрх үүргийг ялган тодорхойлсон байна.
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Үгүй	Хуулийн төсөлд байх бүхий л зохицуулалтыг тусгасан байна.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Тийм	Хяналтаар төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх зохицуулалт илрээгүй.
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Үгүй	Тогтоогоогүй.
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.

	Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;		
13	Хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	-	Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд энэ асуудлыг жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжтой
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	-	Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд энэ асуудлыг Өрсөлдөөний тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжтой
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй	Хяналтаар энэ төрлийн зөрчил илрээгүй.
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	-	Тухайн хуулийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хуулиар зохицуулагдсан болно.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийж үзэхэд хуулийн төслийн зүйл заалт өөр хоорондоо зөрчилдөөгүй байх бөгөөд үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтнуудын чиг үүрэгт давхардал үүсгээгүй байна.

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

4.1. Үнэлэлт, дүгнэлт

Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ, агуулгын дүн шинжилгээг Хууль тогтоомжийн тухай хуулийн⁶ 17 дугаар зүйлд заасны дагуу хийв. Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь зах зээл дээр шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрэх үйл ажиллагааг дэмжин, нийтэд санал болгох, Хөгжлийн банкны засаглал, шийдвэр гаргах эрх хэмжээг тодорхой болгон оновчтой хуваарилах, санхүүжилт авсан этгээдийн эдийн засгийн болон бусад хариуцлагыг нэмэгдүүлэх зэрэгтэй холбогдсон харилцааг шинээр зохицуулж, экспорт импорт, худалдааны санхүүжилтийн үйл ажиллагааг түлхүү хэрэгжүүлж, бизнесийн орчныг дэмжих чиглэсэн тодорхой зохицуулалт тусган боловсруулжээ

Төсөлд тусгасан зарим шинэ харилцаа нь Монгол Улсад анх удаа хуульчлагдаж байгаа тул холбогдох бусад хуулиудын уялдаа холбоог хангах, мөн зохицуулагч байгууллагын батлах дүрэм, журмуудыг тус хуультай уялдан боловсруулахад анхаарах нь чухал юм.

⁶Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. <http://legalinfo.mn/law/details/11119?lawid=11119>.

4.2. Зөвлөмж

Монгол Улсын Хөгжлийн банканд өмнө үүссэн алдаа дутагдлыг арилгах хүрээнд тус банкны засаглал, эрх зүйн орчныг илүү нээлттэй, зохистой болгож өгөх нь эдийн засгийн хөгжилд чухал хувь нэмэр оруулах юм. Иймд банк, худалдааны салбарын салбарын хуульч, судлаач, эрдэмтэд танилцуулж тэдний санал дүгнэлтийг тусгах нь хууль тогтоомжийн хэрэгжилт, үр нөлөөнд чухал ач холбогдолтой гэсэн зөвлөмжийг өгч байна.

4.3. АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Эрх зүйн актууд:

1. Иргэний хууль;
2. Эрүүгийн хууль;
3. Зөрчлийн тухай хууль;
4. Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль;
5. Төв банк (Монголбанк)-ны тухай хууль;
6. Банкны тухай хууль;
7. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль;
8. Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 393 дугаар тогтоолоор батлагдсан “Засгийн газраас МУХБ-ны үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх журам”
9. Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн 252 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Хөгжлийн банкны дүрэм”

Бусад:

1. Үндэсний аудитын газрын 2015 онд хийсэн бие даасан шалгалт тайлан;
2. Засгийн газраас 2016 онд хийсэн хамтарсан шалгалтын тайлан;
3. Үндэсний аудитын газраас 2017 онд хийсэн бие даасан шалгалтын тайлан;
4. Монголбанкнаас 2017 онд хийсэн бие даасан шалгалтын тайлан;
5. Монголбанкнаас 2018 онд хийсэн бие даасан шалгалтын тайлан;
6. Үндэсний аудитын газраас 2019 онд хийсэн бие даасан шалгалтын тайлан;
7. Засгийн газраас 2019 онд хийсэн хамтарсан шалгалтын тайлан;
8. Монголбанкнаас 2021 онд хийсэн бие даасан шалгалтын тайлан;
9. УИХ-ын даргын захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн 2022 онд хийсэн хамтарсан шалгалтын тайлан.
10. УИХ-ын хянан шалгах түр хорооны үйл ажиллагааны тайлан 2023 он;
11. Үндэсний аудитын газраас 2023 онд хийсэн бие даасан шалгалтын тайлан;